



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2024 оны 06 сарын 07 өдөр

Дугаар A/274


Улаанбаатар хот

Г Улсын нэгдүгээр төв эмнэлгийн
дүрэм шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, мөн зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх хэсэг, 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын нэгдүгээр төв эмнэлгийн дүрмийг хавсралт ёсоор баталсугай.
2. Батлагдсан дүрмийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Улсын нэгдүгээр төв эмнэлэг (Б.Хишигжаргал)-т үүрэг болгосугай.
3. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан “Улсын нэгдүгээр төв эмнэлгийн дүрэм, бүтцийг батлах тухай” Эрүүл мэндийн сайдын 2019 оны 7 дугаар сарын 29-ний өдрийн А/368 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (С.Төгсдэлгэр)-т үүрэг болгосугай.

САЙД



С.ЧИНЗОРИГ

111240524

Эрүүл мэндийн сайдын
2024 оны 06 сарын 07-ны өдрийн
9/2024 дугаар тушаалын хавсралт

УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛГИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү дүрмийн зорилго нь Улсын нэгдүгээр төв эмнэлэг /цаашид “Эмнэлэг” гэх-/ийн үндсэн чиг үүрэг, удирдлага, зохион байгуулалтын бүтцийг тодорхойлох, эмнэлгийн болон түүний удирдлагын эрх, үүрэг, үйл ажиллагааны чиглэл, санхүүжилт, хөрөнгийн зохицуулалттай холбогдсон нийтлэг харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Эмнэлэг нь улсын хэмжээнд төрөлжсөн мэргэшлээр эмнэлгийн лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээг үзүүлэх, оношилгоо, эмчилгээний стандарт, эмнэлзүйн заавар, арга аргачлал боловсруулах, сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхлэх, эрүүл мэндийн бусад байгууллагыг мэргэжил, арга зүйгээр хангах чиг үүрэг бүхий төрөлжсөн мэргэшлийн төв эмнэлэг мөн.
- 1.3. Эмнэлэг нь үйл ажиллагаандыа Монгол Улсын хууль тогтоомжийг мөрдлөг болгоно.
- 1.4. Эмнэлэг нь эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шууд удирдлагад харьяалагдан ажиллана.
- 1.5. Эмнэлэг нь Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг болон эрүүл мэндийн салбарын хөгжлийн бодлоготой уялдсан байгууллагын стратеги төлөвлөгөөг эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөлөөр, жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг Эрүүл мэндийн сайдаар батлуулж хэрэгжүүлнэ.
- 1.6. Эмнэлгийн оноосон нэр нь “Улсын нэгдүгээр төв эмнэлэг” байх бөгөөд товчилсон нэр нь “УНТЭ”, англи хэлээр “First Central Hospital of Mongolia” байна. Эмнэлэг нь Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод дараах хууль ёсны хаягт байрлаж үйл ажиллагаа явуулна:
Монгол Улс, Улаанбаатар хот 14210, Сүхбаатар дүүрэг 1 дүгээр хороо, С.Зоригийн гудамж-2;
Утас: 77111027, 80183000;
Факс: 77111027;
Цахим шуудангийн хаяг: info@fchm.edu.mn;
Цахим хуудасны хаяг: <http://www.unte.moh.gov.mn>.
- 1.7. Эмнэлэг нь холбогдох хууль тогтоомжийн дагуу үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас, санхүүгийн харилцах данс, бэлгэдэлтэй байна.
- 1.8. Энэхүү дүрмийн 1.7-д заасан тамга, тэмдгээр эмнэлгийн албан ёсны шийдвэр, албан гэрээ, хэлцлийг баталгаажуулах бөгөөд эмнэлгийн захирлын томилсон албан тушаалтан тамга, тэмдгийг түшнэ.

**Хоёр. Улсын нэгдүгээр төв эмнэлгийн алсын хараа, эрхэм зорилго,
үйл ажиллагааны зорилт, уриа, үнэт зүйлс, зарчим, чиглэл**

2.1. Алсын хараа

Хүн амд үзүүлж байгаа эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээг дэлхийн жишигт хургэнэ.

2.2. Эрхэм зорилго

Үйлчилгээний соёл, анагаах ухааны шинэ технологи, инновацийг эрхэмлэгч, шилдэг багийн тогтолцоотой олон улсын магадлан итгэмжлэгдсэн эмнэлэг болно.

2.3. Эмнэлгийн үйл ажиллагааны зорилт:

2.3.1. эмнэлэг нь эмнэлгийн тусlamж, үйлчилгээний стандарт, технологи, эмнэлзүйн заавар, удирдамжийн дагуу эмнэлзүйн лавлагаа шатлалын тусlamж, үйлчилгээг амбулатори, хэвтүүлэн эмчлэх, оношилгоо шинжилгээний цогц байдлаар чанартай үзүүлэхийн зэрэгцээ сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажлаа тасралтгүй суралцагч байгууллага байх;

2.3.2. хүн амын дунд зонхилон тохиолдох өвчин эмгэг, мэргэжлээс шалтгаалах өвчин, осол гэмтэл, гамшгаас урьдчилан сэргийлэх, тандалт судалгааг хийх, тархалтын хандлагыг тодорхойлох, хоол хүнс, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, эрүүл мэндийн боловсрол олгох арга хэмжээг салбарын бодлогод нийцуулэн хэрэгжүүлэгч, нийгмийн эрүүл мэндийг дэмжигч байгууллага байх;

2.3.3. сургалт эрхлэх зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагатай хамтран эмнэлгийн мэргэжилтнийг мэргэшүүлэх сургалт эрхлэх үндсэн байгууллага байж бусад эмнэлзүйн сургалт эрхлэх байгууллагатай сүлжээ үүсгэн эрүүл мэндийн ажилтан сургах, тэдний чадавхийг дээшлүүлэхэд хамтын оролцоог идэвхжүүлж манлайлж ажиллах;

2.3.4. эмнэлэг нь үйл ажиллагааныхаа чиглэлийн хүрээнд улсын хэмжээнд бусад эрүүл мэндийн байгууллагыг мэргэжлийн арга зүйгээр хангах, цахим сүлжээ ашиглан зайн сургалт, зөвлөгөө өгөх, төрөлжсөн мэргэшлийн эмнэлгээс лавлагаа, мэргэжил арга зүйн дэмжлэг авах зэрэгээр хамтран ажиллаж, хамтдаа зэрэгцэн хөгжих;

2.3.5. бүх хэлбэрийн ялгavarлан гадуурхалт, ажлын байрны дарамт, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх, жендерийн тэгш байдлыг хангах, хүний эрхийг дээдлэх, хүний эрүүл мэнд, хувь хүн, байгууллага, төрийн мэдээллийн нууцыг чандлан хадгалах, үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, ажиллах ээлтэй орчин бүрдүүлэх.

2.4. Уриа

Бид эрүүл мэндийн салбарын анхдагч, манлайлаж байна.

2.5. Эмнэлгийн үнэт зүйлс:

- ууган эмнэлгийн уламжлалт түүх;
- зуун дамжсан арвин туршлага;
- үе үеийн шилдэг хүний нөөц, түүний залгамж чанар;
- эмчилгээ, үйлчилгээндээ нэвтрүүлсэн анагаах ухааны тэргүүлэх ололт амжилт;
- анхдагч манлайлаж нэр хүнд, түүнийгээ хадгалах чадамж;
- дэлхийн шилдэг технологийг эзэмшигч;
- хамт олны хүсэл эрмэлзэл, итгэл үнэмшил.

2.6. Эмнэлэг нь үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтална:

- хууль, хүний эрхийг дээдлэх, ил тод байх, үйлчлэгч болон үйлчлүүлэгчдэд;
- ээлтэй орчин бүрдүүлсэн байх;
- хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг ялгаварлан гадуурхахгүйгээр;
- тэгш, хүртээмжтэй үзүүлэх;
- шинжлэх ухаанд суурилсан инноваци нэвтрүүлэх, анагаах ухааныг хөгжүүлэх;
- мэдлэгт тулгуурласан хөгжил, үнэ цэнийг хамгаалах;
- ёс зүй, харилцаа хандлагыг эрхэмлэж, ажил хэрэгч, хариуцлагатай байх;
- үр дүнд чиглэсэн удирдлагын баг гүйцэтгэлд тохирсон бодит үнэлгээг хийх;
- хөгжлийг эрхэмлэсэн суралцагч хамт олон байх.

2.7. Эмнэлэг нь эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан жагсаалт, журмын дагуу улсын хэмжээнд төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

Гурав. Эмнэлгийн эрх, үүрэг

3.1. Эмнэлэг нь дараах эрх эдэлнэ:

3.1.1. Эмнэлгээс үзүүлж байгаа мэргэшсэн тусламж, үйлчилгээний чиглэлээр улсын хэмжээнд мөрдөгдөх дүрэм, стандарт, эмнэлзүйн заавартай холбоотой санал боловсруулах, нотолгоонд суурилсан мэргэжлийн дүгнэлт гаргаж эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

3.1.2. төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээний чиглэлээр бусад эрүүл мэндийн байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

3.1.3. байгууллагын чиг үүрэг, хөгжлийн бодлоготой уялдсан хүний нөөцийг бүрдүүлж оновчтой байршуулах, тасралтгүй хөгжүүлж чадавхжуулах, материалаг бааз, төсөв бүрдүүлж холбогдох хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах;

3.1.4. эрдэм шинжилгээ, судалгааны төсөл боловсруулан хэрэгжүүлэх, үр дүнг тооцох, үндэсний болон олон улсын хэмжээний эрдэм шинжилгээний хурал зөвлөгөөн, сургалт зохион байгуулах, ном товхимол, зөвлөмж, заавар гарган нийтийн хүртээл болгох;

3.1.5. олон улсын байгууллага, гадаад, дотоодын ижил чиг үүрэг бүхий байгууллагатай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх, хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, судалгаа хийх, туршлага солилцох асуудлаар эрх бүхий төрийн захиргааны төв байгууллагад танилцуулах, мэдээлэх;

3.1.6. тусламж, үйлчилгээг чанартай, хүртээмжтэй, стандарт, зааврын дагуу үзүүлэхэд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, хөрөнгө оруулалтын асуудлаар эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад санал тавьж шийдвэрлүүлэх;

3.1.7. менежментийн шилдэг арга барил, эдийн засгийн үр ашиг, өгөөжийг нэмэгдүүлэх, техник, технологи, орчны шинэчлэл хийх замаар эмчилгээ, оношилгооны нэр төрлийг нэмэгдүүлэх, тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах;

3.1.8. эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан шийдвэрийг үндэслэн зарим тусламж, үйлчилгээг төлбөртэй үзүүлэх;

3.1.9. иргэн, бусад байгууллагын буруутай үйлдлээс эмнэлэг болон эрүүл мэндийн ажилтанд учирсан хохирлыг төлүүлэх асуудлыг Иргэний хуульд заасны дагуу шийдвэрлүүлэх;

3.1.10. Эрүүл мэндийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжоор олгосон бусад эрх.

3.2. Эмнэлэг нь дараах үүрэг хүлээнэ:

3.2.1. Монгол Улсын хөгжлийн бодлого, зорилгод нийцүүлэн үйл ажиллагаа явуулах, эмнэлгийн үйл ажиллагаанд хамаарах зорилго, зорилтыг хэрэгжүүлэх, салбарын хөгжлийн бодлоготой уялдуулан эмнэлгийн хөгжлийн төлөвлөгөөг гарган хэрэгжүүлэх;

3.2.2. тусlamж, үйлчилгээг үйлчлүүлэгчдэд мэргэжлийн өндөр түвшинд чанартай, үзүүлэх, тусlamж, үйлчилгээний чиглэлээр болон байгууллагын үйл ажиллагаанд үндэсний болон олон улсын түвшний магадлан итгэмжлэл авах;

3.2.3. эрүүл мэндийн бусад байгууллагад төрөлжсөн мэргэшлийн тусlamж, үйлчилгээний чиглэлээр зөвлөмж, дүгнэлт гаргаж өгөх мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, арга зүйн удирдлагаар хангаж хамтран ажиллах;

3.2.4. үйлчлэх хүрээний болон зорилtot бүлгийн хүн амын дунд өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгийг зохион байгуулах;

3.2.5. тусlamж, үйлчилгээний чанар сайжруулах, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах, оношилгоо, эмчилгээнд дэвшилтэт техник технологи нэвтрүүлэх чиглэлээр шинжлэх ухаан, судалгаанд суурисан үйл ажиллагааг тогтвортой хэрэгжүүлэх;

3.2.6. хүн амын дунд зохион тохиолдож байгаа өвчлөлийн түвшин, тархалт, нас барагтын шалтгааныг судлах, тандалтын тогтолцоог бий болгон мэдээллийн санг бүрдүүлэх, энэ чиглэлээр хүн ам, төрийн захиргааны төв болон бусад байгууллагыг мэдээллээр хангах;

3.2.7. төгсөлтийн дараах эмнэлзүйн үндсэн болон төрөлжсөн мэргэшлийн сургалт зохион байгуулах;

3.2.8. үйл ажиллагаандaa орчин үеийн мэдээллийн технологийн дэвшилийг нэвтрүүлэн, үйлчлүүлэгчийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангаж цахим эмнэлэг, цахим бүртгэл, цахим өвчний түүхийг ашиглах нөхцөлийг бүрдүүлэх, алсын зайн анагаах ухааныг өргөжүүлэн хөгжүүлэх;

3.2.9. Эрүүл мэндийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлах, өөрийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг эмнэлгийн албан ёсны цахим хуудас болон бусад мэдээллийн сувгаар байгууллага, иргэдэд ил тод мэдээллэх, хувь хүн, гэр бүл хамт олонд эрүүл мэндийн боловсрол олгох, хүн амын дунд эрүүл мэндийг дэмжих орчныг бүрдүүлэх талаар бусад байгууллагатай хамтран ажиллах;

3.2.10. эмнэлгийн мэргэшсэн тусlamж, үйлчилгээний талаар үйлчлүүлэгчдийн санал, хүсэлт, гомдлыг шуурхай хүлээн авч шийдвэрлэх, ирсэн санал, гомдолд дүн шинжилгээ хийж алдаа зэрчлийг запруулах арга хэмжээ авч ажиллах;

- 3.2.11. эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөлд албан хаагчдаас нэр дэвших боломж олгож, сонгон шалгаруулах үйл ажиллагааг ил тод, нээлттэй байдлаар зохион байгуулахад төрийн захиргааны төв байгууллагад дэмжлэг үзүүлэх;
- 3.2.12. хүний нөөцийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу ил тод, нээлттэй байдлаар зохион байгуулах;
- 3.2.13. албан хаагчдын тогтвортой суурьшилтай ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах, мэргэжил ур чадварт тохирсон цалин хөлс олгох, ажлын бүтээмж, үр дүнд суурилсан урамшуулалт олгох, тэднийг мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалтад хамруулахдаа шударга, ил тод, нээлттэй байдлаар шийдвэрлэх;
- 3.2.14. албан хаагчдын мэргэжлийн ур чадвар, сахилга хариуцлагыг сайжруулах, төрийн албан хаагчийн болон эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлэн хэвшил болгох арга хэмжээг тогтмол хэрэгжүүлэх;
- 3.2.15. эмнэлгийн барилга байгууламж, оношилгоо, эмчилгээний багаж, төхөөрөмж болон холбогдох бусад техник хэрэгсэл нь эрүүл ахуйн болон стандартын шаардлага хангасан, эрүүл мэндийн ажилтны хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны нөхцөлийг бүрдүүлсэн байх;
- 3.2.16. санхүү, төсвийн нээлттэй, ил тод зарчмыг баримтлан санхүүгийн нөөцийн төлөвлөлт хийх, оновчтой хуваарилалтыг хэрэгжүүлж ажиллах;
- 3.2.17. үндсэн болон төсөвт хөрөнгийн ашиглалтын зарцуулалт, үр ашгийг дээшлүүлэх, нягтлан бодох бүртгэл, тасаг, алба, нэгжийн аж ахуйн тооцоо, байгууллагын орлого, зарлагын дотоодын хяналт, шалгалтыг тогтмолжуулах;
- 3.2.18. үйл ажиллагаанд авлига авах, өгөх, албан тушаалын байдлаа аливаа хэлбэрээр урвуулан ашиглах, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, хууль бус үйлдэл, үйл ажиллагааг хориглох, урьдчилан сэргийлж ажиллах;
- 3.2.19. жендерийн эрх тэгш байдлыг хангах, бүх хэлбэрийн ялгаварлан гадуурхалт, ажлын байрны дарамт, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах, хүний эрхэд ээлтэй орчин бүрдүүлж ажиллах;
- 3.2.20. эмнэлгийн зохион байгуулалтын бүтцийн нэгж нь эмнэлгийн шийдвэрээр хүлээсэн үүрэг, дотоод журмыг биелүүлэх;
- 3.2.21. Эрүүл мэндийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжоор хүлээлгэсэн бусад үүрэг.

Дөрөв. Эмнэлгийн гадаад, дотоод хамтын ажиллагаа

- 4.1. Эмнэлгийг гадаад, дотоод хамтын ажиллагаанд эмнэлгийн захирал төлөөлнө.
- 4.2. Эмнэлгийн захирлын гадаад улсад туршлага судлах, мэргэжлийн сургалтад хамрагдах, хурал, семинарт оролцох болон орон нутагт ажиллах албан томилолтыг Эрүүл мэндийн сайд шийдвэрлэнэ.

4.3. Гадаад орны эрүүл мэндийн байгууллага, төвтэй хамтын ажиллагааны гэрээ, санамж бичиг байгуулах замаар эмнэлгийн албан хаагчдыг сургах, дадлагажуулах, олон улсын хуралд оролцох, хамтарсан судалгаа хийх нөхцөлийг бурдүүлнэ.

4.4. Албан хаагчдыг гадаад, дотоодод томилолтоор ажиллуулах, суралцах асуудлыг эмнэлгийн захирал шийдвэрлэнэ.

4.5. Захирал нь Эрүүл мэндийн сайд, Дэд сайд, Төрийн нарийн бичгийн дарга, яамны газрын дарга нартай шууд харьцаж эрүүл мэндийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг биелүүлэх ажлыг зохион байгуулах үүрэг, чиглэл, зөвлөмж авч үйл ажиллагааг уялдуулан ажиллана.

4.6. Эмнэлэг нь өөрийн эрхлэх асуудлын хүрээнд бусад эрүүл мэндийн байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, иргэдтэй шууд харилцана.

Тав. Эмнэлгийн санхүүжилт

5.1. Эмнэлгийн санхүүжилт нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

5.1.1. улсын төсөв;

5.1.2. эрүүл мэндийн даатгалын сангаас гүйцэтгэлээр хийгдэх санхүүжилт;

5.1.3. үндсэн (хууль тогтоомжоор зөвшөөрсөн төлбөртэй тусlamж, үйлчилгээний орлого) болон үндсэн бус (хууль тогтоомжид нийцүүлэн олсон бусад орлого гэх мэт) үйл ажиллагааны орлого;

5.1.4. төсвийн тухай хуульд заасны дагуу Монгол Улсын болон гадаадын иргэн, хуулийн этгээд, хувь хүний хандив, тусlamж;

5.1.5. гадаад, дотоодын хөрөнгө оруулалт;

5.1.6. төсөл, хөтөлбөрийн санхүүжилт;

5.1.7. хууль тогтоомжид заасан бусад эх үүсвэр.

5.2. Санхүүжилт, эд хөрөнгийг байгууллагын зорилго, зорилт, хууль тогтоомж, энэ дүрэмд нийцүүлэн зориулалтын дагуу зарцуулж, зарцуулалтын ил тод байдлыг хангана.

5.3. Эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үндсэн хөрөнгө бүртгэлд авах, тэдгээрийг данснаас хасах, шилжүүлэх, актлах саналаа холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.

5.4. Эд хөрөнгийн тооллогыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар тогтоосон хугацаанд, холбогдох журмын дагуу явуулна.

5.5. Нягтлан бodoх бүртгэлийн үйл ажиллагааг Монгол Улсын Нягтлан бodoх бүртгэлийн тухай хууль, Олон улсын нягтлан бodoх бүртгэлийн стандартын дагуу гүйцэтгэж аудит хийлгэнэ. Аудиторыг гэрээний үндсэн дээр сонгон ажиллуулж аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг хангана.

5.6. Эд хөрөнгө, санхүү, нягтлан бodoх бүртгэл, тооцоонд тавих өөрийн болон хөндлөнгийн хяналтыг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлнэ.

Зургаа. Эмнэлгийн удирдлага, зохион байгуулалт

6.1. Эмнэлгийн удирдлагын тогтолцоо нь Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага буюу эмнэлгийн захирал, түүний дэргэдэх Захирлын зөвлөлөөс бүрдэнэ.

6.2. Эмнэлгийн тусlamж, үйлчилгээний тухай хуульд заасны дагуу зохион байгуулсан сонгон шалгаруулалтад тэнцэж Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолоор томилогдсон захирал эмнэлгийн гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлнэ.

6.3. Захирал нь энэ дүрэм болон эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөлийн баталсан сонгон шалгаруулалтын дагуу удирдах албан тушаалтан болон бусад албан хаагчийг сонгон шалгаруулж томилж ажиллуулна.

6.4. Эмнэлэг нь Эмнэлзүй, Үйл ажиллагаа, Сувилахуйн асуудал эрхэлсэн дэд захиралтай байна.

6.5. Эмнэлгийн захирал нь дэд захирал, бүтцийн нэгж болон захиргааны албадын удирдлага, хамт олны төлөөллөөс оролцуулан Захирлын зөвлөл байгуулж ажиллах журмыг тогтооно.

6.6. Эмнэлэг нь эрдэм шинжилгээний ажлын хэтийн болон ойрын зорилт, тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, судалгаа шинжилгээний сэдэв, арга зүй, явц, дүнг хэлэлцэх, тэдгээрт үнэлэлт, дүгнэлт гаргах үүрэг бүхий Эрдмийн зөвлөл ажиллуулах бөгөөд зөвлөлийн дүрэм, бүрэлдэхүүнийг холбогдох хууль тогтоомж, Шинжлэх ухаан, технологийн зөвлөлөөс ирүүлсэн саналыг үндэслэн эмнэлгийн захирал батална.

6.7. Эмнэлгийн захирал нь тушаал, захирлын болон Эрдмийн зөвлөл нь хурлын шийдвэр, тэмдэглэл гаргана.

6.8. Эмнэлэг нь дэргэдээ Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороо, Дотоод хяналтын баг, Эмийн эмчилгээний зохицуулах хороо, Өмч хамгаалах байнгын зөвлөл, Хөдөлмөрийн эрхийн маргаан таслах комисс болон бусад шаардлагатай зөвлөл, хороог ажиллуулна.

Долоо. Эмнэлгийн захирлын эрх, үүрэг

Эмнэлгийн захирал дараах эрх, үүрэгтэй:

7.1. эрүүл мэндийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, төрөлжсөн мэргэшлийн лавлагана шатлалын эмнэлгийн тусламж, үйлчилгээг зохион байгуулах нэгдсэн удирдлагыг хэрэгжүүлж байгууллагын үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг дээшлүүлэх, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлэх, албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах чиг үүргийн хүрээнд байгууллагын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, гүйцэтгэлийн үр дүнг Эрүүл мэндийн сайд болон Төлөөлөн удирдах зөвлөлийн өмнө хариуцах;

7.2. эрүүл мэндийн талаарх хууль тогтоомжийг боловсронгуй болгох, улсын хэмжээнд баримтлах бодлого чиглэл болон стандарт, журам, эмнэлзүйн заавар, тушаал, шийдвэр боловсруулахад оролцож санал өгөх;

7.3. эмнэлгийн үйл ажиллагаа, санхүү, төсвийн гүйцэтгэл, эрүүл мэндийн статистик мэдээ, тайланг тогтоосон хугацаанд нь хүргүүлэх;

7.4. төсвийн ерөнхийлөн захирагч болон Төлөөлөн удирдах зөвлөлтэй жил бүр эмнэлгийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн төлөвлөгөөг байгууллагын стратеги төлөвлөгөөтэй уялдуулан батлуулж хэрэгжилтийг тайлгаха, ил тод мэдээлэх;

7.5. Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан төсвийн хуваарийн дагуу эмнэлгийн төсвийг захиран зарцуулах, тухайн төсвийн жилийн батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан эмнэлгийн орон тоо, албан хаагчдын цалин хөлсийг тогтоох;

7.6. байгууллагын дотоод журам, эмнэлгийн бүтцийн нэгжийн үйл ажиллагааны чиглэл, чиг үүрэг, ойрын болон хэтийн хөгжлийн стратеги төлөвлөгөөг баталж хэрэгжилтэд хяналт тавих;

7.7. албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг батлан хөдөлмөрийн гэрээ байгуулж үр дүнг дүгнэх, томилох, шилжүүлэх, сэлгэн ажиллуулах, шагнах, урамшуулах, сахилгын шийтгэл оногдуулах, албан тушаал бууруулах, хөдөлмөрийн гэрээг цуцлах;

7.8. эмнэлгийн хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэх, нийгмийн хамгааллыг дэмжих хүрээнд хүний нөөцийн дунд хугацааны төлөвлөлт, нийгмийн хамгааллын хөтөлбөр гарган хэрэгжүүлэх;

7.9. эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс олгосон эрх, хэм хэмжээний хүрээнд хэлэлцээр хийх, гэрээ байгуулах зэргээр эмнэлгийн гүйцэтгэх удирдлагыг бүрэн хэмжээгээр төлөөлж үйл ажиллагааны үр дүнг хариуцах;

7.10. гамшиг, осол, нийтийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед эмнэлгийн хэмжээнд гамшгийн штабын даргын үүрэг хүлээн, гамшгийн үеийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг удирдан зохион байгуулах;

7.11. удирдах ажилтны болон салбар, мэргэжлийн ёс зүйг чанд сахиж үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж ажиллах;

7.12. авлигаас ангид байх, үйл ажиллагааны тогтвортой байдал, жендерийн эрх тэгш байдал, аливаа хэлбэрийн ялгаварлан гадуурхалтыг арилгах, урьдчилан сэргийлж ажиллах;

7.13. Төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан гэрээ, албан тушаалын тодорхойлолт, хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.

Найм. Эмнэлгийн дэд захирлын нийтлэг чиг үүрэг

8.1. Эмнэлгийн дэд захирлууд нь дараах нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлнэ:

8.1.1. төрийн албан хаагчийн болон мэргэжлийн ёс зүйг чанд сахиж, үйл ажиллагааны нээлттэй ил тод байдлыг хангаж ажиллах;

8.1.2. авлигаас ангид, аливаа хэлбэрийн ялгаварлан гадуурхалтыг арилгах, жендерийн эрх тэгш байдлыг хангах, ажлын байрны дарамт, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хориглох арга хэмжээг зохион байгуулах;

8.1.3. манлайлал, эрүүл мэндийн болон бусад салбарын дэвшилтэт арга барил, хөгжлийн үр дүнтэй санаачилгыг дэмжиж ажиллах;

8.1.4. тасаг, нэгжийн удирдлагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж үр дүнг хагас, бүтэн жилээр үнэлэн тайлагнах;

8.1.5. хөдөлмөрийн гэрээ, албан тушаалын тодорхойлолт, хууль тогтоомжоор хүлээсэн бусад үүргийг биелүүлэн ажиллах.

8.2. Эмнэлзүй эрхэлсэн дэд захирал дараах эрх, үүрэгтэй:

8.2.1. эрүүл мэндийн салбарын шинэчлэлийн бодлоготой уялдуулан байгууллагын эмнэлзүйн үйл ажиллагааны хөгжлийн бодлого, тусламж, үйлчилгээний тэргүүлэх чиглэлийг тодорхойлж түүнтэй уялдсан хөгжлийн төлөвлөгөөгт хэрэгжүүлэх, эмнэлгийн тусламж, үйлчилгээг сайжруулах менежмент, оношилгоо

эмчилгээний шинэ дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, нутагшуулах үйл ажиллагааг зохион байгуулах, шинэ технологийн нэгдсэн сан үүсгэн баримтжуулж хадгалах;

- 8.2.2. батлагдсан стандарт, технологи, заавар, удирдамж, хөтчийн дагуу үйлчилүүлэгчид эмнэлзүйн тусламж, үйлчилгээг амбулаторийн болон хэвтүүлэн эмчлэх, оношилгоо шинжилгээний цогц байдлаар эрсдэлгүй хүргэх үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалт, арга зүйгээр хангаж ажиллах;
- 8.2.3. төрөлжсөн мэргэжлийн эмч нарын хамтарсан үзлэг, зөвлөгөөн, эмгэг судлалын хэлэлцүүлгийг удирдан зохион байгуулах, үйл ажиллагаанд гарсан алдаа зөрчил, үл тохирлыг арилгах, эмнэлзүйн тусламж, үйлчилгээний тандалт судалгаа хийх, судалгааны дүнд үндэслэн тусламж, үйлчилгээний зохион байгуулалтыг сайжруулах;
- 8.2.4. эмнэлзүйн заавар, удирдамж, арга аргачлал боловсруулах, батлуулах ажлыг удирдан чиглүүлэх, мөрдүүлж ажиллах, гүйцэтгэлд хяналт тавих, төрөлжсөн мэргэжлийн чиглэлийн орон тооны бус салбар зөвлөлүүдийг удирдах;
- 8.2.5. эмнэлгийн эмийн бодлого, төлөвлөлтийн хүрээнд эм зүйн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангаж, эмчилгээний өндөр идэвхтэй, чанарын баталгаатай, аюулгүй эм, эмнэлгийн хэрэгслийн хангамжийг хариуцах;
- 8.2.6. эрүүл мэндийн салбарын шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэл, техник технологи, хүний нөөцийн хөгжлийн цогц бодлоготой уялдуулан эмч, эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн бодлогыг тодорхойлон эмнэлгийн гадаад, дотоод хамтын ажиллагааг хөгжүүлэх;
- 8.2.7. эмч, эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх, мэргэжил эзэмших, дээшлүүлэх, мэргэжлийн болон боловсролын зэрэг ахиулах, аттестатчилах зэрээр эмнэлзүйн үйл ажиллагаанд шаардлагатай хүний нөөцийн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх;
- 8.2.8. эмч, эмнэлгийн мэргэжилтний хөгжил, мэргэшүүлэх, давтан сургах үйл ажиллагааг холбогдох эрх зүйн орчинд нийцүүлэн батлагдсан хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу зохион байгуулах, төгсөлтийн дараах эмнэлзүйн сургалт эрхлэх чиглэлээр сүлжээ эмнэлгийн тогтолцоог бий болгон, хэрэгжилтийг ханган ажиллах, сургалтын орчин, дэд бүтэц, хөгжлийн бодлого, удирдлагын чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллах;
- 8.2.9. эмнэлгийн Эрдмийн зөвлөлийн үйл ажиллагааг хариуцаж, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын нэгдсэн санг баяжуулах, эмч мэргэжилтний эрдэм судалгааны ажлыг дэмжих, олон улсын мэргэжлийн сэтгүүлд хэвлэн нийтлүүлэхэд туслалцаа үзүүлэх, эрдэм шинжилгээ, судалгаа, хөгжлийн төсөл, хөтөлбөр, шинжлэх ухаан, технологийн захиалгат төсөл боловсруулж хэрэгжүүлэх ажлыг удирдлагаар хангах;
- 8.2.10. хүн амын өвчлөл, өвчний тархалт, нас баралтыг тандан судлах, судалгаа шинжилгээний ажил эрхлэх, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг эмнэлгийн хэмжээнд зохион байгуулах;

8.2.11. эмнэлзүйн асуудалтай холбогдох бүхий л асуудлаар эмнэлгийг бүрэн төлөөлөн, хариуцлага хүлээх, шаардлагатай тохиолдолд уулзалт, хурал, зөвлөгөөн, хэлэлцээрт эмнэлгийг төлөөлөн оролцох.

8.3. Үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирал дараах эрх, үүрэгтэй:

8.3.1. эрүүл мэндийн салбарын хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөөтэй уялдуулан байгууллагын алсын хараа, хэтийн зорилгыг үйл ажиллагааны үндсэн чиглэлтэй холбон тодорхойлж хэрэгжүүлэх урт, богино, дунд хугацааны стратеги төлөвлөгөөг батлуулах;

8.3.2. эмнэлгийн бүхий л үйл ажиллагааны хэвийн, бэлэн байдлыг хангахад шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, бусад эд хөрөнгөөр хангах, бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтыг хууль эрх зүйн хүрээнд зохион байгуулах, удирдан чиглүүлэх, гүйцэтгэлд хяналт тавих, тайлagnaх;

8.3.3. эмнэлгийн богино болон дунд хугацааны төлөвлөгөөт ажилд шаардагдах хөрөнгө оруулалтын хэмжээг тооцоолж гаргах, төлбөрт тусламж, үйлчилгээний тарифын үндэслэл, өргийн тооцоог гаргах, үр ашгийг дээшлүүлэх, эмнэлгийн орлогын эх үүсвэрийг бүрдүүлэх, зардлыг хямдруулах, хэмнэх, эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалтын хугацаа, хэрэглээний нэгдсэн судалгаанд суурилан төлөвлөлт хийж хэрэгжилтийг ханган ажиллах;

8.3.4. эмнэлгийн жил бүрийн төсвийн төслийг боловсруулах, эмнэлгийн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг удирдлага, арга зүй, зохион байгуулалтаар ханган ажиллах;

8.3.5. барилгын их болон урсгал засварын төлөвлөлт, гүйцэтгэлд хяналт тавих, аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах, гэрээний явц, гүйцэтгэлийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;

8.3.6. эмнэлгийн эмнэлзүйн болон бусад үйл ажиллагааны цахим бүртгэл, мэдээллийн хэвийн байдлыг хангах, мэдээллийн нууцыг хадгалах, хамгаалах үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, хяналт тавих;

8.3.7. эмнэлгийн тусламж, үйлчилгээнд Технологийн нэгдсэн санг үүсгэн баримтжуулж хадгалах, тоног төхөөрөмжийн ашиглалтын хугацаа, хэрэглээний нэгдсэн судалгаанд суурилан үр ашигтай төлөвлөлт хийх;

8.3.8. эмнэлгийн дотоод хяналт, шинжилгээ, үнэлгээний ажилд манлайлан оролцох, гамшгийн үеийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлөвлөлтийг хариуцан ажиллах.

8.4. Сувилахуй эрхэлсэн дэд захирал дараах эрх, үүрэгтэй:

8.4.1. эрүүл мэндийн салбарын шинэчлэлийн бодлоготой уялдуулан эмнэлгийн сувилахуйн тусламж, үйлчилгээний болон сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтний хөгжлийн бодлогыг тодорхойлон эмнэлгийн сувилахуйн тусламж, үйлчилгээний өдөр тутмын үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллах;

8.4.2. эмнэлгийн сувилахуйн тусламж, үйлчилгээг төлөвлөх, удирдах, үнэлэх;

- 8.4.3. сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтний ур чадварыг дээшлүүлэх, тогтвортой суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр санал боловсруулан шийдвэр гаргуулах;
- 8.4.4. сувилахуйн тусламж, үйлчилгээний ажлын ачааллыг бууруулах, цагийн менежментийг сайжруулах, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнийг бүтцийн нэгжүүдэд хуваарилах, үйл ажиллагааг нь зохицуулах чиглэлээр хүний нөөцийн асуудал хариуцсан нэгжтэй хамтран ажиллах;
- 8.4.5. сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтний ажил амьдралын тэнцвэрт байдлыг дэмжих ажлын таатай орчныг бүрдүүлэх;
- 8.4.6. онцгой байдлын үед бэлэн байдлыг хангах, сувилахуйн тусламж, үйлчилгээний гүйцэтгэлд хяналт тавих;
- 8.4.7. нотолгоо (тоо баримт, судалгааны тайлан, нөөц бололцоо, бусад мэдээлэл)-нд тулгуурлан сувилахуйн тусламж, үйлчилгээний чанар, бүтээмжийг сайжруулах, шинэ технологи, арга хэрэгсэл нэвтрүүлэх, инновацыг дэмжих чиглэлээр төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх;
- 8.4.8. эмнэлгийн хэмжээнд бүтцийн нэгж, мэргэжлийн баг, ажилтан хоорондын харилцаа, хамтын ажиллагааг хангах аргачлал, дүрэм, журмыг тогтоох, хэрэгжилтийг хянах;
- 8.4.9. үйлчлүүлэгчид үзүүлэх сувилахуйн тусламж, үйлчилгээний аюулгүй байдлыг хангах хөтөлбөр хэрэгжүүлэх, шинэ соёл, тусламж, үйлчилгээг сурталчлах, зохион байгуулах.

Ес. Бусад

- 9.1. Эмнэлгийн тусламж, үйлчилгээ нь эмнэлгийн эмнэлэүйн болон дэмжин туслах чиглэлийн нэгжүүдийн нэгдмэл үйл ажиллагаагаар зохицуулагдана.
- 9.2. Эмнэлгийн зохион байгуулалтын бүтэц, алба, нэгжийн чиг үүрэг, эрх хэмжээг Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолоор батална.
- 9.3. Энэхүү дүрэм нь Эрүүл мэндийн сайдын тушаал батлагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.
- 9.4. Эмнэлгийн дүрэм хүчин төгөлдөр болж үйлчилж эхэлснээр эмнэлгийн нийт албан хаагчид дагаж мөрдөнө.
- 9.5. Энэхүү дүрэмд Эрүүл мэндийн сайдын тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулна.

---ooOoo---